

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Өсөхбаяр</p> <p>Утас: 99890393 Цахим хаяг: Usukhbayarj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан /төгрөгөөр/	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	8
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа	13
8.2 Төлбөрийн акт	13
8.2 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.03.15 № 2/148

БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ ЦТ ХХК-
ИЙН ЗАХИРАЛ Ж.УЛАМБАЯР ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 005020679

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	615,985,880.69	460,083,423.49
1.1.2	Дансны авлага	142,244,269.82	192,934,215.29
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.02	462,726.04
1.1.4	Бусад авлага	78,545,147.33	95,438,720.87
1.1.6	Бараа материал	259,323,415.86	296,995,962.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	185,430,993.05	275,180,030.42
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,281,529,706.77	1,321,095,078.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,233,690,390.48	19,071,285,328.02
1.2.2	Биет бус хөрөнгө	427,664,305.93	449,266,600.93
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,661,354,696.41	19,520,551,928.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,942,884,403.18	20,841,647,007.08
2.1.1.1	Дансны өглөг	14,711,998.12	6,812.42
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	31,932.01
2.1.1.3	Татварын өр	34,869.47	42,233,987.22
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	14.09
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	40,579,284.96
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	12,846,426.58	25,439,968.42
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	27,593,294.17	108,291,999.12
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	585,712,044.99	504,553,475.07
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	585,712,044.99	504,553,475.07
2.2	Өр төлбөрийн нийт дүн	613,305,339.16	612,845,474.19
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,426,737,382.97	1,426,737,382.97
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,027,341,582.02	5,027,341,582.02
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	15,801,335,459.53	16,116,347,100.71
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,925,835,360.80)	(2,341,624,533.06)
2.3.11	Эздийн өмчийн дүн	20,329,579,063.72	20,228,801,532.64
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,942,884,402.88	20,841,647,006.83

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,152,708,380.15	11,264,528,073.52
2	Борлуулалтын өртөг	7,185,425,694.11	8,297,027,321.20
3	Нийт ашиг (алдагдал)	2,967,282,686.04	2,967,500,752.32
5	Хүүний орлого	18,370,952.36	2,102,340.91
8	Бусад орлого	417,845,415.20	279,054,932.36
9	Борлуулалт, маркетингийн зардал	651,985,030.92	643,023,567.32
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,356,242,754.55	2,746,411,193.35
11	Санхүүгийн зардал	6,816,671.82	6,195,909.12
12	Бусад зардал	343,689,149.61	268,606,293.97
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(37,408,514.15)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	7,356,932.55	(415,578,938.17)
19	Орлогын татварын зардал	1,837,095.24	210,234.09
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,519,837.31	(415,789,172.26)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,519,837.31	(415,789,172.26)
24	Орлогын нийт дүн	5,519,837.31	(415,789,172.26)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	13,869,774,828.77	(1,931,355,198.10)	18,392,498,595.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(0.02)	(0.02)
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	13,869,774,828.77	(1,931,355,198.11)	18,392,498,595.65
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,519,837.31	5,519,837.31
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,931,560,630.76	-	1,931,560,630.76
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	15,801,335,459.53	(1,925,835,360.80)	20,329,579,063.72
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	15,801,335,459.53	(1,925,835,360.80)	20,329,579,063.72
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(415,789,172.26)	(415,789,172.26)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	315,011,641.18	-	315,011,641.18
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,116,347,100.71	(2,341,624,533.06)	20,228,801,532.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,283,832,822.04	9,786,169,865.45
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орло	8,849,713,897.51	3,697,294,391.91
	Бусад мөнгөн орлого	434,118,924.53	6,088,875,473.54
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,417,117,501.64	9,726,979,684.65
	Ажиллагчдад төлсөн	1,088,616,145.23	1,138,650,105.46
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	383,307,980.86	357,442,670.39
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,281,358,800.00	4,137,376,312.54
	Ашиглалтын зардалд төлсөн	281,412.04	51,940,185.60
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгс	41,546,348.00	37,608,502.00
	Хүүний төлбөрт төлсөн	3,408,335.91	-
	Татварын байгууллагад төлсөн	300,919,165.45	170,546,976.88
	Даатгалын төлбөрт төлсөн	4,596,470.00	10,013,299.66
	Бусад мөнгөн зарлага	3,313,082,844.15	3,823,401,632.12

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(133,284,679.60)	59,190,180.80
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,919,150.31	-
	Хүлээн авсан хүүний орлого	14,919,150.31	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	215,092,638.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	204,446,838.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,645,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр м	14,919,150.31	(215,092,638.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(118,365,529.29)	(155,902,457.20)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэ	734,351,409.98	615,985,880.69
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлд	615,985,880.69	460,083,423.49

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн зорилго нь “Стандартын цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх борлуулах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж сүлжээний алдагдлыг багасган хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр соёлтой, чанартай үйлчилгээг үзүүлж шударга харилцааг эрхэмлэн ажиллах” -д оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Эрдэнэт, Булган, Хархорин Өвөрхангай аймгийн 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч дамжуулан авч хэрэглэгчдэд түгээх” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 154 тоот тогтоолд аймгуудын эрчим хүчний газрыг 1965-1967 онд багтаан байгуулахаар заасны дагуу 1966 оны 04 дүгээр сарын 01-д Баянхонгор аймгийн төвд Эрчим хүчний үйлдвэр анх байгуулагдсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2002 оны 78 дугаар тогтоолоор 100 хувь орон нутгийн өмчит “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК болон өөрчлөгдөн зохион байгуулагджээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт “Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг хэрэгцээ шаардлагын дагуу нэмэгдүүлж гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станц шинээр байгуулан албан байгууллага, айл өрхүүдийг шөнийн тарифт, ухаалаг тоолуурт шилжүүлэх” тухай заалт тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-гэж заасан байна.

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолоор 2021 оны үйл ажиллагааны зардлыг 2,262,516.7 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2,136,573.4 мянган төгрөгийг зарцуулж, 132,414.0 мянга буюу нийт зардлын 6.0 хувийг хэмнэж ажилласан байна.

Мөн компанийн Төлөөн удирдах зөвлөлөөс баталсан бүтэц орон тоо нь Баянхонгор аймгийг цахилгаан эрчим хүчээр хангах үед зайлшгүй шаардлагатай бүрэлдэхүүн тул хэмнэх боломжгүй юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,281,529.7	1,321,095.1	39,565.4
Мөнгөн хөрөнгө	615,985.9	460,083.4	(155,902.5)
Авлага	220,789.4	288,835.7	68,046.2
Урьдчилгаа	185,431.0	275,180.0	89,749.0
Бараа материал	259,323.4	296,996.0	37,672.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,661,343.3	19,520,551.9	(140,791.3)
Үндсэн хөрөнгө	28,128,633.4	29,008,818.9	880,185.4
Хуримтлагдсан элэгдэл	(8,467,290.2)	(9,488,266.9)	(1,020,976.8)
Нийт хөрөнгө	20,942,873.0	20,841,647.0	(101,226.0)
Нийт өр төлбөр	613,306.3	612,845.5	(460.9)
Богино хугацаат өр төлбөр	27,594.3	108,292.0	80,697.7
Урт хугацаат өр төлбөр	585,712.0	504,553.5	(81,158.6)
Эздийн өмч	20,329,566.7	20,228,801.5	(100,765.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,942,873.0	20,841,647.0	(101,226.0)

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 460,083.4 мянган төгрөг болж 155,902.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 288,835.7 мянган төгрөг болж 68,046.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд ажиллагсадтай холбоотой дотоод журмын дагуу олгосон 5,023.2 мянган төгрөгийн зээлийн авлага үүссэн, Хот тохижилт ОНӨААН-ээс авах Баянхонгор сумын гүний худгийн цахилгааны шугам сүлжээний 12,978.5 мянган төгрөгийн авлага, Баянхонгор сумаас авах хуучийн замын кемпийн цахилгааны шугам сүлжээний 14,343.6 мянга төгрөгийн авлага, аймгийн ЗДТГ-аас авах төрийн байгууллагуудын сургалтын төвийн шугам сүлжээний 34,952.7 мянган төгрөгийн авлага тус тус үүссэн мөн Засгийн газраас авах айл өрхийн цахилгааны хөнгөлөлтийн авлага 76,464.3 мянга, шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага 54,050.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Харин айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас авах цахилгааны авлага өмнөх оноос 77,912.0 мянган төгрөгөөр буурч 26,826.4 мянган төгрөг болсон үзүүлэлттэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 296,996.0 мянган төгрөг болж 37,672.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь худалдах зориулалттай бараа 3,819.6 мянга, хангамжийн материал 23,054.8 мянга, тосолгооны материал 7,196.3 мянга, бусад материал 3,723.3 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,008,818.9 мянган төгрөг болж 880,185.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж 880,185.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 612,845.5 мянган төгрөг болж 460.9 мянган төгрөгөөр буурсан нь богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 80,697.7 мянган төгрөгөөр нэмэгдэж урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 81,158.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 80,697.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хувь хүний орлогын албан татвартай холбоотой 5,622.7 мянга, нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой 36,609.4 мянган төгрөгийн өр үүссэнийг бүртгэж урт хугацаат зээлийн 2022 онд төлөгдөх үндсэн зээлийн төлбөр болох 40,579.3 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 81,158.6 мянган төгрөгөөр буурсан тайлант онд 40,579.3 мянган төгрөгийн зээлийн төлбөр төлөгдөж мөн 2022 онд төлөгдөх үндсэн зээлийн төлбөрийг богино хугацаат өр төлбөрөөр шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 20,228,801.5 мянган төгрөг болж 100,765.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 415,789.1 мянган төгрөгөөр буурч аймгийн ИТХ-ын тогтоолоор 315,011.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч эздийн өмчийг нэмэгдүүлсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 5,027,341.6 мянган төгрөг байгаа ба тайлант онд өөрчлөлт гараагүй болно.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2021 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 10,824,763.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 11,92,396.6 мянган төгрөгөөр нийт ашиг алдагдлыг 567,633.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 11,545,685.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11,961,264.3 мянган төгрөгийн зардал гарган 415,579.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 11,545,685.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 903,973.6 мянган төгрөг буюу 8.3 хувиар нэмэгдсэн байгаа нь худалдсан цахилгаан эрчим хүчний орлого 515,463.6 мянга, түгээх үйлчилгээний орлого 54,001.2 мянга, бусад орлого 152,671.5 мянган төгрөгөөр төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 11,961,264.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 593,323.9 мянган төгрөг буюу 5.2 хувиар нэмэгдсэн байгаа нь худалдсан цахилгаан эрчим хүчний орлого нэмэгдсэнтэй холбоотой худалдан авсан цахилгаан эрчим хүчний зардал 539,444.5 мянга, бусад гадагш чиглэсэн үйлчилгээний орлого нэмэгдсэнтэй холбоотой үйл ажиллагааны бус зардал 122,804.1 мянган төгрөгөөр төлөвлөснөөс хэтэрсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Зардлын төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Тайлант оны	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
0	ХАЦЭХ	7,185,425.694	7,758,582.8	8,297,027.3
1	Шатахууны зардал	31,320.6	33,546.1	39,572.3
2	Тээврийн зардал			
3	Сэлбэг хэрэгсэл	34,564.8	34,370.0	33,832.5
4	Урсгал засвар	66,501.3	83,674.6	76,381.1
5	Материал, хангамжийн материал	3,327.7		
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	1,229,582.6	1,346,965.0	1,320,812.4
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	181,939.9	208,779.6	202,555.8
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	11,676.6	11,172.7	9,742.3
9	Ашиглалтын зардал-Дулаан	89,493.5	105,937.6	90,780.0
10	Ашиглалтын зардал-Ус	4,065.1	3,527.6	3,425.0
11	Албан томилолтын зардал	3,566.0	11,288.0	9,470.5
12	Контторын хангамжийн зардал	2,852.9	3,800.0	3,821.1
13	Харилцаа холбооны зардал	5,646.2	9,458.2	3,692.7
14	Харуул хамгаалалтын зардал	22,972.7	25,200.0	23,631.9
15	Хөдөлмөр хамгааллын зардал	25,068.4	47,141.0	26,383.4
16	Даатгалын зардал	13,611.5	13,611.5	13,560.4
17	Галын аюулаас хамгаалах зардал		3,000.0	
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	185,971.4	189,959.0	181,435.7
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	23,518.8	33,402.6	30,097.9
20	Хяналтын зөвлөлийн зардал			
21	Борлуулалт, маркетингийн зардал	6,891.9	5,500.0	5,489.4
22	Диспетчерийн зардал			
23	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	9,750.0	10,609.0	9,070.0
24	Гадны үйлчилгээний хөлс	12,764.8	8,564.9	15,789.0
25	Түрээсийн зардал			
26	Сургалтын зардал	9,745.0	16,890.0	7,610.8
27	Найдваргүй авлагын зардал	3,913.9	3,377.2	3,409.4
28	Үйл ажиллагааны бусад зардал	681.8	1,242.2	1,277.7
29	Гамшигаас хамгаалах зардал	4,460.4	51,500.0	24,732.1
Үйл ажиллагааны зардлын дүн		1,983,887.6	2,262,516.7	2,136,573.4
30	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	180,223.606	149,980.0	182,865.7
31	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	739,752.779	792,020.7	838,122.5
Элэгдлийн зардлын дүн		919,976.385	942,000.7	1,020,988.2
32	Үл хөдлөх хөрөнгийн татвар	13,659.522	13,353.7	13,790.5
33	АТӨЯХ-ийн албан татвар	924.694	975.7	753.5
34	Газрын төлбөр		4,143.3	498.8
35	Бусад татвар хураамж			
Орлогын албан татвараас бусад татварын дүн		14,584.216	18,472.7	15,042.8
36	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	6,816.672	46,775.2	6,195.9
37	Ажиллагсдын нийгмийн зардал	103,441.522	234,348.4	230,620.9
Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн		110,258.2	281,123.6	236,816.8
38	Үйл ажиллагааны бус зардал	367,438.1	129,700.0	254,815.8
39	Валютын ханшны алдагдал			
НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43/		10,581,570.187	11,392,396.6	11,961,264.285
40	Борлуулалтын орлого	7,494,522.4	8,036,877.3	8,552,340.9
41	Түгээх үйлчилгээ орлого	2,658,186.0	2,658,186.0	2,712,187.2
42	Бусад орлого	436,216.4	129,700.0	281,157.0
НИЙТ ОРЛОГО /46+47-45/		10,588,924.8	10,824,763.3	11,545,685.1
43	ТАТВАРЫН ДАРААХИ АШИГ/АЛДАГДАЛ	7,354.6	(567,633.3)	(415,579.2)

Эх сурвалж: “Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны орлого, зардлын төлөвлөгөө

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ж.Уламбаяр танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 36 тоот албан бичгээр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг 2021 оны 01 дүгээр сарын 13 хүртэл захирал Т.Отгонбаатар, 2021 оны 01 дүгээр сарын 13-аас эхлэн захирал Ж.Уламбаяр, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 05 дугаар сарын 05 хүртэл ерөнхий нягтлан бодогч Б.Батбаатар, 2021 оны 05 дугаар сарын 05-аас эхлэн ерөнхий нягтлан бодогч Б.Хорлоо нар зурсан байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын бүтцэд дотоод хяналтын ажилтан гүйцэтгэх удирдлагын шууд удирдлагад ажиллаж байгаа ба дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж байна.

Дотоод хяналт шалгалтаар тайлант онд нийт 13 албан тушаалтанд алдаа, зөрчлийг арилгах 73 зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,583,413.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 158,751.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 111,125.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцоход 125,593.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 1,694,677.6 мянган төгрөгийн 121 мэдээлэл оруулахаас хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 164,188.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн алдаа, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын дотоод хяналтын ажилтан нь дотоод хяналт шалгалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж 13 албан тушаалтанд 73 зөвлөмж

өгсөн ч 10 албан тушаалтан 42 зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар тайлан ирүүлээгүй байгаа тул дотоод хяналтын үр нөлөөг гаргаж зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхийг хянаж үзэх.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 57,139.1 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, 41,852.2 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,980.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,306.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөв.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 41,852.2 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

1. Тайлан хугацаанд 3 албан хаагчийн 1,243.4 мянган төгрөгийн илүү олгосон амралтын мөнгийг буцааж тушаалгахдаа цалингийн зардлыг бууруулаагүй үйл ажиллагааны бус орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын гуравдугаар бүлэг дэх “...Орлоготой холбогдож гарсан борлуулалтын өртөг болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана...” гэсэн заалттай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн орлого үр дүнгийн тайланд залруулав.

2. Тайлант онд 4 харилцагчийн 29.5 мянган төгрөгийн авлагын илүү төлөлтийг тохируулаагүйгээс 29.5 төгрөгийн хасах дүнтэй авлага үүссэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 2 дахь “...Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна...” гэсэн заалттай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн байдлын тайланд авлагын дансанд залруулав.

3. Тус байгууллагын зээлийн үлдэгдэл 545,132.8 мянган төгрөг байгаа үүнээс 40,579.3 мянган төгрөг нь гэрээгээр 2022 онд төлөгдөхөөр байгаа ч богино хугацаат өр төлбөрөөр тайлагнаагүй нийтэд нь урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 10 дахь “...урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг... энэ хэсэгт толилуулна...” гэсэн заалттай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд өр төлбөрийн дансанд залруулав.

8.2 Төлбөрийн акт

Тус байгууллагын ажилтнуудын нормын хувцас бэлтгэн нийлүүлэгч “Шүрэн гүүр” ХХК-д 1,980.0 мянган төгрөг илүү шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч “Шүрэн гүүр” ХХК-иар илүү олгосон 1,980.0 мянган төгрөгийг орон нутгийн бусад татвар хураамжийн 100030000947 тоот дансанп буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ТУЗ-ын 2021 оны 02 дугаар тогтоолоор баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан шатахуун, материал хангамж, борлуулалт маркетинг, гаднын үйлчилгээний хөлс, үйл ажиллагааны бусад зардлуудыг батлагдсан төсвөөс 13,306.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг хэтрүүлэн зарцуулдаг явдлыг зогсоож цаашид батлагдсан төлөвлөгөөнд багтаан хөрөнгийг зарцуулж байх зөвлөмж өгөв.

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1694677.6 мянган төгрөгийн 121 мэдээлэл оруулахаас хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 164188.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6 дахь “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар:																
1	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	Тайлан хугацаанд 3 албан хаагчийн 1,243.4 мянган төгрөгийн илүү олгосон амралтын мөнгийг буцааж тушаалгахдаа цалингийн зардлыг бууруулаагүй үйл ажиллагааны бус орлогоор бүртгэсэн байна.	Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.	1	1243.3	1	1243.3								
2	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	Тайлант онд 4 харилцагчийн 29.5 мянган төгрөгийн авлагын илүү төлөлтийг тохируулаагүйгээс 29.5 төгрөгийн хасах дүнтэй авлага үүссэн байна.	Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.	1	29.5	1	29.5								
3	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	Тус байгууллагын зээлийн үлдэгдэл 545,132.8 мянган төгрөг байгаа үүнээс 40,579.3 мянган төгрөг нь гэрээгээр 2022 онд төлөгдөхөөр байгаа ч богино хугацаат өр төлбөрөөр тайлагнаагүй нийтэд нь урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан байна.	Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.	1	40579.3	1	40579.3								
4	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	Тус байгууллагын ажилтнуудын нормын хувцас бэлтгэн нийлүүлэгч “Шүрэн гүүр” ХХК-д 1,980.0 мянган төгрөг илүү шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.	Бэлтгэн нийлүүлэгч “Шүрэн гүүр” ХХК-иар илүү олгосон 1,980.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.					1	1980.0						
5	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	ТУЗ-ын 2021 оны 02 дугаар тогтоолоор баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан шатахуун, материал хангамж, борлуулалт маркетинг, гаднын үйлчилгээний хөлс, үйл ажиллагааны бусад	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг хэтрүүлэн зарцуулдаг явдлыг зогсоож											1	13306.9

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			зардлуудыг батлагдсан төсвөөс 13,306.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	цаашид батлагдсан төлөвлөгөөнд багтаан хөрөнгийг зарцуулж байх зөвлөмж өгөв.												
ДҮН					5	57139.1	3	41852.2	1	1980.0					1	13306.9
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
6	“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК	БНА-2022/1/Н А-СТА-ОНӨААН	Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1694677.6 мянган төгрөгийн 121 мэдээлэл оруулахаас хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 164188.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.	1	-									1	-
ДҮН					1	-									1	-
НИЙТ ДҮН					6	57139.1	3	41852.2	1	1980.0					2	13306.9

оОо